



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/912

Баруун-Урт сум

Үл хөдлөх дурсгалын улсын тооллого
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Засгийн газрын 2018 оны 184 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Соёл урлагийн газрын даргын 2021 оны А/45 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”- ийн 2.1.4-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 2021 оны 12 сард зохион байгуулсугай.

2. Үл хөдлөх дурсгалын улсын тооллого зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, тооллогод зарцуулах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Үл хөдлөх дурсгалын улсын тооллогод шаардагдах 1,383,900 (нэг сая гурван зуун наян гурван мянга есөн зуун) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (П. Мөнхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Улсын тооллогыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулахыг Ажлын хэсэг (Х.Эрдэнэдэлгэр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М. ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 19- ний өдрийн 1/712 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Ажлын хэсэг байгуулах тухай

Ажлын хэсгийн ахлагч:

Х. Эрдэнэдэлгэр -Соёлын хэлтсийн дарга

Гишүүд:

Д. Ариундэлгэр -Угсаатны зүйн музейн дарга

Ч. Оюун-Эрдэнэ -Угсаатны зүйн музейн сан хөмрөгч

Д. Ариунболд -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлалын мэргэжилтэн

-Сумдын Соёлын төвийн дарга

-Сумдын бүртгэл мэдээллийн ажилтан

-Жолооч

Нарийн бичиг:

Б. Золхүү -Соёлын хэлтсийн ахлах мэргэжилтэн